



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/14/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууняа
Утас: 51-261663 Цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn
Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлаг аудитор: П.Амарсангаа
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: nuamsurenn@audit.gov.mn
Аудитор: Ж.Мэнхтуул
Утас: 261628 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/.....	8
2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Няялан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтуүд	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө	13
3.4.2 Авлага.....	14
3.4.3 Бараа материал	14
3.4.4 Үндсэн хөрөнгө.....	15
3.4.5 Өр төлбөр	16
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.5.1 Төсвийн төлөвлөлт	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	17
3.5.3 Нэмэлт төсөв.....	17
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	18
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.3.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	20
4.4 Судалгааны үр дүн	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
4.5.1 Завсрын аудитын талаар.....	22
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
5. АУДИТЫН ИПРҮҮЛЭЛТ.....	23
5.1 Төлбөрийн акт	23
5.2 Албан шаардлага.....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЗД	Баянзүрх дүүрэг
НУБГ	Нийслэлийн улсын бүртгэлийн газар
СНАГ	Санхүү, Нийцлийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨДХХК	Төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингисийн дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ У.БОЛДХҮҮ
ТАНАА

2025.03.05 № 01/2018

таний нийтийн №

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгүүд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлзэ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толишуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохицтой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааны жагсаалтад ороогүй 24,181.8 сая төгрөгийн үндсэн түүхий эд материалыг шууд худалдан авсан;
- Харьяа Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК бизнес төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд төлөвлөж, холбогдох байгууллагад хургуулээгүй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж батлаулахгүйгээр 5,968.5 сая төгрөгийг зарцуулсан;
- Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 3,172.3 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүсгэж, барагдуулах арга хэмжээг аваагүй;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг зөрчин худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй 141.7 сая төгрөгийн барааг нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр худалдан авсан;
- Бараа материалын дансанд 3 төрлийн 25000 ширхэг нийт 15.9 сая төгрөгийн хэрэгцээ шаардлагагүй, цаас нөөцөлсөн;

- Бараа материалын тооллого хийхэд 1664 ширхэг 113.7 сая төгрөгийн цахим гадаад паспортын бэлдцийг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д шилжүүлэх албаны үйлдсэн боловч бараа материалыг бодитоор шилжүүлэн бөгөөд байна;
- Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 244.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дунгээрээ санхүүгийн тайланд материалын нэвтрээг боловч өргөн тархаагүй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох", 2 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх-/ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 13 дахь хэсгийн 11-т "Төрийн болон албаны нууцын тухай хууль Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр" мөн хэсгийн 12-т "байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт", 73 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормос хэтэрсэн дутагдал гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэг хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д "Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилсан эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна", 75 дугаар зүйлийн 75.6-д "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдод тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээс хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ" Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Санхүү, төсвийн зохистой удирдах, төсвийг үр ашигтай байхар төлөвлөх зарцуулах", 6.4.8-д "Төсвийн зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хэрээнд дотоод аудитын үйл ажиллагаагааг хэрэгжүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөн шаардлагатай бараа, материалыг үр ашигтой удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Еренхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэх нийтийн төлбөр, худалдан авагчтай тооцоо хийх, улдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагнанын "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Оршин байх", "Эрх ба үүрэг", "Их бүрэлдэх байдал" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 2024/02 дугаар хурлын тогтоолоор ногдол ашигийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн олгохоор шийдвэрлэж, Унгар улсаас худалдан авсан

Чиитэй гадаад паспортын бэлдцийн 938,906 европийн төлбөрийг бүрэн төлж, барагдуулах саналыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны эзлжит сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс нийт 1,054.3 сая төгрөгийн санхүүжилт авч, мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах, сонгуулийн бэлтгэл ажлыг гүйцэтгэх ажлаар албан хаагчид гадаад улс дахь элчин сайдын яамдад гадаад албан томилолтоор ажилласан байна.

Аудитын гол асуудал

Терийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн терийн хувь эзэмшлийн 51.0 хувийг эзэмшдэг Улсын буртгэлийн ерөнхий газрын даргы Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 171 дугаар тогтоолоор ажлаас чөлөөлж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн Б/9 дүгээр тушаалаар тус газрын даргын албан үүргийг тур орлон гүйцэтгэгчийг томилсон боловч төрийн хувь эзэмшлийн хувьцаа эзэмшигчийг томилоогүйгээс Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийгээгүй, компанийн төсөв, төлөвлөгөөг батлаагүй, үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй байна. Авлигатай тэмцэх газраас тус компанийн 2 үндсэн ажилтанд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллахад ашиг сонирхол үүсэхгүй гэсэн мэдэгдэл гаргаж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг алдаатай гаргаж ирүүлснийг аудитын явцад залруулга хийлгэсэн боловч залруулсан тайланг хуульд заасан хугацаанаас хоцроож, 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 1/4311 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

Бусад асуудал

Улсын буртгэлийн ерөнхий газар болон Терийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн бараа материалын үлдэгдэлд биет тооплого хийх явцад буруу мэдээлэл өгөх, хуурамч баримт бүрдүүлэх эзргээр аудит хийхэд хүндэрэл учруулсан нь аудитын тайлан, дүгнэлт хугацаандaa гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох буртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох буртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.



Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн зэйн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Я.САМБУУНИЯМ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

КОД:	ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2023 ОНЫ 12-Р САРЫН 31	2024 ОНЫ 12-Р САРЫН 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,536,254.0	21,389,116.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	622,881.8	462,981.4
33	АВЛАГА	3,397,657.4	1,886,145.3
34	УРЬДЧИЛГАА	1,042,235.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	11,894,480.1	19,039,989.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	7,578,999.7	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	73,341,201.9	90,896,261.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	73,341,201.9	90,896,261.8
39200	БИЕТ ХӨРӨНГӨ	57,854,916.9	77,907,691.1
39300	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	15,486,285.0	12,988,570.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	97,877,455.9	112,285,378.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,860,609.5	3,363,633.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,860,609.5	3,363,633.8
41300	ӨГЛӨГ	5,399,056.5	3,355,869.7
41400	УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО	461,553.0	7,764.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	92,016,846.4	108,921,744.1
51	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	92,016,846.4	108,921,744.1
51100	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	12,211,503.2	12,211,503.2
51101	ӨМЧ /ТӨРИЙН/ /ТӨҮГ/	-	16,138,690.0
51102	ӨМЧ /ХУВИЙН/ /ТӨҮГ/	-	15,483,203.0
51200	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	79,294,558.9	64,577,563.6
51300	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨРYY	510,784.3	510,784.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	97,877,455.9	112,285,378.0

01

ТОГИЙН АУДИТЫН БАЙГУУЛСАА
ХЯГДААРЛАЛТАЙ
САНАЛ ДУГААДАА

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	114,727,983.8	123,816,958.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	26,067,054.8	15,885,433.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	26,067,054.8	15,885,433.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,705,719.9	12,652,095.6
120	Нийтлэг татварын бус орлого	27,705,719.9	12,652,095.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,955,209.1	95,279,428.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	83,657,420.8	125,823,097.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,657,420.8	125,823,097.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,757,936.3	115,013,880.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,616,576.0	39,492,663.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,588,172.4	4,958,538.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,072,046.4	1,363,447.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,021,503.6	1,501,755.2
2105	Нормативт зардал	-	1,500.0
2106	Эд хогшил, ургсал засварын зардал	223,424.8	179,937.0
2107	Томилолт, зочны зардал	33,302.5	103,177.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,597,512.3	10,923,863.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,605,398.4	56,488,996.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	899,484.5	10,809,217.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	31,070,563.0	(2,006,139.5)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,079,601.8	8,984,841.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	28,990,961.2	(10,990,981.2)

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/


Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГОЙН ДҮН (I)	137,390,479.8	187,867,443.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	52,393,870.6	23,437,376.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	52,393,870.6	23,437,376.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	52,393,870.6	23,437,376.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,026,400.2	69,219,332.2
120	Нийтлэг татварын бус орлого	24,026,400.2	69,219,332.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,970,209.1	95,210,735.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	112,895,991.0	179,737,699.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	112,895,991.0	179,737,699.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,446,059.9	125,352,481.1
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	27,313,577.4	41,291,312.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,954,414.6	5,133,830.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтол зардал	1,115,945.6	1,541,338.2
2104	Хангамж, бараа материалын зардал	19,855,117.5	28,073,924.3
2105	Норматив зардал	-	1,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,498.3	198,964.7
2107	Томилолт, зочны зардал	33,302.5	88,157.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,892,247.0	20,505,526.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,070,957.0	28,517,926.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,449,931.1	54,385,217.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	24,494,488.8	8,129,744.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	23,912,653.1	5,312,765.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,912,653.1	5,312,765.5
2200	Дотоод эх үүсвэрээр	23,912,653.1	5,312,765.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(23,912,653.1)	(5,312,765.5)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(79,389.7)	(2,976,879.7)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	79,389.7	2,976,879.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	502,445.9	(159,900.4)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	120,435.9	622,881.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	622,881.8	462,981.4

2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	63,025,885.2	-	63,025,885.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	63,025,885.2	-	63,025,885.2
9	Тайлант үеийн үр дүн	28,990,961.2	-	28,990,961.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,016,846.4	-	92,016,846.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,726,014.2)	-	(3,726,014.2)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,290,832.3	-	88,290,832.3
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	23,520.0	-	23,520.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	31,598,373.0	-	31,598,373.0
19	Тайлант үеийн үр дүн	(10,990,981.2)	-	(10,990,981.2)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	108,921,744.1	-	108,921,744.1




2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛҮЙН ДҮН	93,520,303,900.00	90,618,180,042.47	(2,902,123,857.53)	96.9
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	87,235,503,900.00	86,946,482,892.47	(289,021,007.53)	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,651,556,100.00	82,421,340,779.11	(230,215,320.89)	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,284,300,800.00	38,136,384,010.56	(147,916,789.44)	99.6
210101	Үндсэн цалин	22,170,222,800.00	22,245,885,690.20	75,662,890.20	100.3
210102	Нэмэгдэл	10,827,806,800.00	10,541,356,069.05	(286,450,730.95)	97.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,180,748,800.00	4,054,841,561.25	(125,907,238.75)	97.0
210104	Урамшуулал	1,016,113,600.00	1,200,653,148.30	184,539,548.30	118.2
210105	Гэрээт ажлын хөлс	89,408,800.00	93,647,541.76	4,238,741.76	104.7
2102	Ажил олготчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,843,809,600.00	4,809,447,631.66	(34,361,968.34)	99.3
210201	Тэтгэврийн даатгал	3,386,459,400.00	3,344,732,658.77	(41,726,741.23)	98.8
210202	Тэтгээхийн даатгал	364,323,700.00	367,871,556.07	3,547,856.07	101.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	182,162,700.00	184,161,348.14	1,998,648.14	101.1
210204	Ажилгүйдлийн даатгал	182,162,700.00	182,561,486.74	398,786.74	100.2
210205	Эрүүл мэндийн даатгал	728,701,100.00	730,120,581.94	1,419,481.94	100.2
2103	Байр ашиглалтай холбоотой тогтолц зардал	1,400,284,800.00	1,364,495,103.26	(35,789,696.74)	97.4
210301	Гэрэл, цахилгаан	329,627,900.00	317,079,566.01	(12,548,333.99)	96.2
210302	Түвш, халаалт	715,006,100.00	714,331,558.26	(674,541.74)	99.9
210303	Цэвэр, бохир ус	94,350,800.00	74,458,378.99	(19,892,421.01)	78.9
210304	Байрны түрээс	261,300,000.00	258,625,600.00	(2,674,400.00)	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	892,665,900.00	887,514,471.78	(5,151,428.22)	99.4
210401	Бичиг хэрэг	523,209,200.00	520,502,232.00	(2,706,968.00)	99.5
210402	Тээвэр, шатахуун	93,193,500.00	91,884,402.14	(1,309,097.86)	98.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	104,273,300.00	105,573,748.76	1,300,448.76	101.2
210405	Хог хаягдال зайдуулах, хортон мэргэцдийн устгал, ариутгал	21,627,400.00	20,846,253.88	(781,146.12)	96.4
210406	Бага үнэтэй, түргэн элзэгдэх, ахуйн эд зүйлс	150,362,500.00	148,707,835.00	(1,654,665.00)	98.9
2106	Эд хогшил, түргсл засварын зардал	225,773,300.00	223,472,636.00	(2,300,664.00)	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,034,900.00	73,554,940.00	(1,479,960.00)	98.0
210603	Хөдөлмөр хамгаалалын хэрэглэл	17,614,500.00	15,704,000.00	(1,910,500.00)	89.2
210604	Үргсл засвар	133,123,900.00	134,213,696.00	1,089,796.00	100.8
2107	Томилолт, зочны зардал	84,701,700.00	84,293,700.00	(408,000.00)	99.5
210702	Дотоод албан томилолт	84,701,700.00	84,293,700.00	(408,000.00)	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,557,142,600.00	8,553,454,304.85	(3,688,295.15)	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,168,535,500.00	6,166,809,034.85	(1,726,465.15)	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,984,000.00	7,984,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	35,704,800.00	35,704,248.00	(552.00)	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,907,900.00	2,518,132.00	(389,768.00)	86.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	632,700.00	573,708.00	(58,992.00)	90.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,102,899,900.00	1,102,670,554.00	(229,346.00)	100.0
210807	Газрын төлбөр	6,276,600.00	5,359,628.00	(916,972.00)	85.4
210809	Үлсын мэдээллийн маягт халз, бэлтгэх	1,232,201,200.00	1,231,835,000.00	(366,200.00)	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,362,877,400.00	28,362,278,921.00	(598,479.00)	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,285,774,300.00	28,285,774,300.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	77,103,100.00	76,504,621.00	(598,479.00)	99.2
213	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,583,947,800.00	4,525,142,113.36	(58,805,686.64)	98.7
2132	Бусад урслал шилжүүлэг	4,583,947,800.00	4,525,142,113.36	(58,805,686.64)	98.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	736,755,500.00	681,453,660.16	(55,301,839.84)	92.5
213208	Хөдөө орон нутагт тогтворт суурьшилтай ажилласан албан хаагчдад төреөс үзүүлэх дэмжлэг	3,484,124,300.00	3,481,869,953.20	(2,254,346.80)	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	363,068,000.00	361,818,500.00	(1,249,500.00)	99.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,284,800,000.00	3,671,697,150.00	(2,613,102,850.00)	58.4
220001	Барилга байгууламж	2,534,800,000.00	0	(2,534,800,000.00)	-
222001	Тоног төхөөрөмж	3,750,000,000.00	3,671,697,150.00	(78,302,850.00)	97.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮССВЭР	93,520,303,900.00	90,618,180,042.47	(2,902,123,857.53)	96.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93,520,303,900.00	90,605,598,437.47	(2,914,705,462.53)	96.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	93,520,303,900.00	90,605,598,437.47	(2,914,705,462.53)	96.9
35	ТӨСВӨТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	12,581,605.00	12,581,605.00	-
350001	Үндсан үйл ажиллагааны орлогooс санхүүжих	-	240,000.00	240,000.00	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогooс санхүүжих	-	12,341,605.00	12,341,605.00	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2517	2517	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	100.0
610001	Төсвийн байгууллага	23	23	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1247	1247	-	100.0
620001	Удирдах ажилтан	40	40	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1062	1062	-	100.0
620003	Үйлчээх ажилтан	145	145	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1247	1247	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (Т3)	1048	1048	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	199	199	-	100.0



2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР 33ЭЛИЙН ДУН		8,806,733,133.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,786,901,083.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,095,982,121.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,333,007,868.16
210101	Үндсэн цалин		190,430,588.22
210102	Нэмэгдэл		972,441,109.67
210104	Урамшуулал		147,305,165.00
210105	Гэрээт ажлын хөлс		22,831,005.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		171,348,865.86
210201	Тэтгэврийн даатгал		136,655,893.66
210202	Тэтгэмжийн даатгал		9,388,824.09
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,548,429.20
210204	Ажилгүйдлийн даатгал		4,028,357.73
210205	Эрүүл мэндийн даатгал		16,727,361.18
2104	Хангамж, бараа материалын зардал		9,107,255.00
210401	Бичиг хэрэг		7,978,855.00
210402	Тээвэр, шатахуун		1,128,400.00
2105	Нормативт зардал		1,500,000.00
210502	Хоол, хүнс		1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,127,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,000,000.00
210604	Урсгал засвар		6,127,400.00
2107	Томилот, зочны зардал		3,864,000.00
210702	Дотоод албан томилот		3,864,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		117,971,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		17,971,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		100,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		5,450,055,532.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		5,443,495,532.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		6,560,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,690,918,961.33
2132	Бусад урсгал шилжүүлэг		32,619,091.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		32,619,091.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,658,299,870.33
213305	Улсын төсвээс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,543,490,947.39
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		114,808,922.94
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		19,832,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр		19,832,050.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		19,832,050.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		8,806,733,133.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		8,806,733,133.18
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,806,421,859.61
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвээс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,465,989,309.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,534,321,963.75

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын бүртгэлийн ерөнхий газрын эрхэм зорилго нь улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд орших багаад Монгол Улсын төр, засгаас улсын бүртгэлийн чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, олон нийтэд чанартай, шуурхай хүргэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус газар хуульд заасны дагуу дараах чиг, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах;
- Бүх шатны бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтөх, хадгалах, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;
- Салбарын хэмжээний мэргэжлийн боловсон хучний чадавх, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;
- Улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг нэгтгэх, мэдээлэх, мэргшүүлэх сургалт зохион байгуулах, үйл ажиллагаанд хэрэглэх баримт бичгийн загвар, маягт, холбогдох заавар, журмыг хуульд заасны дагуу баталж мөрдүүлэх;
- Улсын бүртгэлийн аргачлал, арга зүйг олон улсын ангилал, стандартын жишигт нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гаргаж мөрдүүлэх.


3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль,
- Иргэний Улсын бүртгэлийн тухай хууль,
- Эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль,
- Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дунд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтооолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт



шинжилгээ, үнэлгээ хийж, тухай бүр зөвлөмж өгч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайллагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайллагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны А/904 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан, шинэчлэхээр Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран салбарын баримт бичгийг боловсруулж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 463.0 сая төгрөг болж, өмнөх оноос 159.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0.1	-	(0.1)
Банканд байгаа бэлэн мөнгө	617.4	463.0	(154.4)
Төгрөг	606.4	462.9	(143.5)
Төрийн сангийн харилцах	546.1	362.6	(183.5)
Арилжааны банк дахь харилцах	60.3	100.3	40.0
Гадаад валют	11.0	0.0	(11.0)
Арилжааны банк дахь харилцах	11.0	0.0	(11.0)
Замд явaa мөнгө	5.4	-	(5.4)
Дун	622.9	463.0	(159.9)

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 159.9 сая төгрөгөөр буурсан нь төсөвт байгууллагын төрийн сангийн харилцахын үлдэгдэл 183.4 сая төгрөг, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн гадаад валютын харилцах дансны үлдэгдэл 11.0 сая төгрөг, замд явaa мөнгөн хөрөнгө 5.4 сая төгрөг, кассад байгаа мөнгө 0.1 сая төгрөгөөр тус тус буурч, Арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл 40.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн ТҮЗ-ийн гишүүд тус үйлдвэрийн үндсэн ажилтны тогтмол цалин болон ТҮЗ-ийн гишүүний цалинтай давхардуулан 36.4 сая төгрөгийг авсан;

- УБЕГ-ЫН /төв аппарат/ Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалинг Засгийн газрын тогтоолоор баталсан дүнгэс илүү тогтоож, 13.1 сая төгрөгийн цалинг олгосон;
- Ховд аймгийн УБХ 13.5 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал, шийдвэрлүгээр олгосон;
- Дархан-Уул аймгийн УБХ 7.1 сая төгрөгийн орон нутагт ажилласны нэмэгдэл цалинг илүү олгосон;
- Орхон аймгийн УБХ 5.4 сая төгрөгийн урамшууллыг, улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон;
- Архангай аймгийн УБХ 3.3 сая төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан;
- Баянхонгор аймгийн УБХ 1.5 сая төгрөгийн тэтгэмжийг цалингийн зардлаас олгосон;
- Булган аймгийн УБХ 1.5 сая төгрөгийн балансын урамшуулалт олгосон;
- Өмнөговь аймгийн УБХ 1.1 сая төгрөгийн шагналын дагалдах мөнгөн урамшууллыг цалингийн сангаас олгосон.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,886.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,241.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	4.1	14.0	9.9
Татаас, санхүүжилтийн авлага	-	1,062.7	1062.7
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	608.2	720.6	112.4
Байгууллагаас авах авлага	4.3	86.7	82.4
Хувь хүмүүсээс авах авлага	28.1	2.2	(25.9)
Дүн	644.7	1,886.2	1,241.5

Зх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайллан

Авлагын дансны 1,886.2 сая төгрөгийн үлдэгдэлд УБЕГ-ЫН Сангийн яамнаас авах татаас, санхүүжилтийн 1,062.6 сая төгрөгийн, Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн тус аймгийн Засаг даргын Тамгын газраас авах 85.5 сая төгрөгийн, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн харилцагч байгууллагуудаас авах 720.5 сая төгрөгийн авлагууд тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Сэлэнгэ аймгийн УБХ нийгмийн даатгалын шимтгэлийг давхардуулан шилжүүлж, 10.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн;
- Булган аймгийн УБХ нийгмийн даатгалын 1.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 19,040.0 сая төгрөг болж, өмнөх оноос 7,145.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	7,293.2	10,064.9	2,771.7
Тусгай зориулалттай материал	7,293.2	10,064.9	2,771.7
Бэлэн бүтээгдэхүүн	2,818.0	6,559.9	3,741.9
Хангамжийн материал	1,752.0	2,381.1	629.1
Бичиг хэргийн материал	114.2	144.1	29.9
Аж ахуйн материал	1,404.6	1,548.7	144.1
Сэлбэг хэрэгсэл	30.5	470.4	439.9
Тулш, шатах тослох материал	3.6	14.0	10.4
Барилгын засварын материал	3.0	0.2	(2.8)
Хүчиний материал	2.7	6.2	3.5
Бусад хангамжийн материал	193.4	197.5	4.1
Мал амьтад	31.2	34.1	2.9
Дүн	11,894.4	19,040.0	7,145.6

Зх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайллан

Бараа материалын дансны үлдэгдэл 19,040.0 сая төгрөг болж өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 61,058.5 сая төгрөг, үнэ төлбергүй хүлээн авсан 1,354.8 сая төгрөг, малын нас дэвшилт 15.0 сая төгрөг, гадаад паспортын бэлдэц 24,337.0 сая төгрөг, нийт 86,765.3 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 78,141.2 сая төгрөг, данс хооронд шилжүүлсэн 1,323.2 сая төгрөг, акталж, устгасан 155.4 сая төгрөг, нийт 79,619. сая төгрөгийн бараа материал хасагдсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл өсөхөд тусгай зориулалтны материал буюу үнэт цаас 2,771.7 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 3,741.9 сая төгрөгөөр, бичиг хэргийн материал 29.0 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 435.5 сая төгрөгөөр, тулш, шатах тослох материал 7.3 сая төгрөгөөр, хүнсний материал 3.5 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 3.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн бараа материалын дансанд бүртгэлтэй 113.7 сая төгрөгийн үнэт цаасыг хүлээж авсан акт үйлдсэн боловч үнэт цаасыг биетээр хүлээж аваагүй, хэрэгцээ шаардлагагүй 15.9 сая төгрөгийн бараа материалын нөөцлсөн;
- Нийслэлийн УБХ бичиг хэрэг, аж ахуй хангамжийн материал худалдан авах 28.2 сая төгрөгийн гэрээнд бараа материалын тоо ширхэг үнийг тусгаагүй, УБЕГ-аас дүүргийн хэлтсүүдэд 7.1 сая төгрөгийн хангамжийн материалыг үнэ төлberгүй шилжүүлсэн, 30.0 сая төгрөгийн цэвэрлэгээний машиныг холбогдох тушаал шийдвэрлгүйгээр данснаас хассан;
- УБЕГ-ын /төв аппарат/ нэмэлт гэрээ байгуулахгүйгээр 21.2 сая төгрөгийн барааг худалдан авсан, ашиглалтаас хасагдсан ТҮЦ машины 11.9 сая төгрөг лавлагааны маягтыг хүлээн авч бүртгэсэн, дансны ангилал зөрүүлэн 3.3 сая төгрөгийн барааг худалдан авсан;
- Сэлзингэй аймгийн УБХ 0.2 сая төгрөгийн барааг ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан;
- Өвөрхангай аймгийн УБХ анхан шатны баримт бүрдэл дутуу 9.0 сая төгрөгийн бараа материалыг бүртгэсэн.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 90,896.3 сая төгрөг болж, өмнөх оноос 17,555.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл
төгрөгөөр/ /сая

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	57,854.9	77,907.7	20,052.8
Барилга, байгууламж, орон сууц	23,023.7	30,644.0	7,620.3
Авто-тээврийн хэрэгсэл	918.2	788.9	(129.3)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	32,201.7	44,882.5	12,680.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,690.9	1,531.6	(159.3)
Бусад үндсэн хөрөнгө	20.4	60.7	40.3
Биет бус хөрөнгө	15,486.3	12,988.6	(2,497.7)
Программ хангамж	15,005.5	12,463.5	(2,542.0)
Бусад биет бус хөрөнгө	480.8	525.1	44.3
Дун	73,341.2	90,896.3	17,555.1

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн наатгасэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 90,896.3 сая төгрөг болж өсөхөд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5,312.8 сая төгрөг, дотооддоо шилжүүлсэн 23,886.1 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 17,331.0 сая төгрөг үлдэх өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг бусад орлогоор 1,475.0 сая төгрөгөөр тус тус нөлөөлсөн байна. Акталж устгасан 4,183.4 сая төгрөг, дотооддоо шилжүүлсэн 17,443.3 сая төгрөг, үлдэх өртөггүй болж хасагдсан 383.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгийн өсөлтэд "Компанийн төрийн мэдлийн ногдол хувьд тооцон хөрөнгө шилжүүлэх тухай" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг газрын 2024 оны 234 дүгээр тогтооолыг хэрэгжүүлэн Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК Улсын бүртгэлийн ерөнхий газраас

16,115.2 сая төгрөг, Мигасон ХХК-аас 15,483.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийг үнэ төлбөргүй хүлээн авсан нь голлон нелөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртийн дээд хязгаарыг зөрчин худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй 141.7 сая төгрөгийн барааг нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр худалдан авсан.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 3,363.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2,497.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	5,399.1	3,355.9	(2,043.2)
Ажилчидтай холбогдсон өглөг	1.9	100.6	98.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,628.8	2,727.3	98.5
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	-	183.6	183.6
Бусад өглөг	2,768.4	344.3	(2,424.0)
Байгууллагад төлөх өглөг	2,768.0	12.7	(2,755.3)
Хувь хүмүүст төлөх өглөг	0.4	0.8	0.5
Татварын өглөг /ТӨҮГ/	-	330.8	330.8
Урьдчилж орсон орлого	461.6	7.8	(453.8)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	59.6	7.8	(51.9)
Барьцаа дэнчингийн урьдчилж орсон орлого	401.9	-	(401.9)
Дүн	5,860.6	3,363.6	(2,497.0)

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өглөгийн дансны үлдэгдэл буурахад Улсын бүртгэлийн ерөнхий газар нь Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д гадаад паспортын бичилтийн мөнгө 2,752.9 сая төгрөгийн өглөгийг төлсөн, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК харилцагч байгууллагуудад өгөх 2,618.0 сая төгрөгийг төлж, барагдуулсан нь голлох нелөө үзүүлсэн байна.

Өглөгийн дансны 3,363.6 сая төгрөгийн үлдэгдэлд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ий татварын байгууллагад төлөх 330.8 сая төгрөг, харилцагч байгууллагад төлөх 2,774.4 сая төгрөг, Говьсүмбэр, Өвөрхангай, Увс, Ховд аймгийн УБХ-ийн татварын 31.3 сая төгрөг, барьцаа дэнчингийн урьдчилж орсон орлогын 183.6 сая төгрөг, 2 аймгийн түлш халаалтын 19.7 сая төгрөг, бусад аймгийн 23.8 сая төгрөгийн өглөгүүд тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайландаа харьяа байгууллагуудын өр төлбөр 3,172.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 112,285.4 сая төгрөг болж, өмнөх оноос 14,407.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,211.5	12,211.5	-
Өмч /Төрийн/ /ТӨҮГ/	-	16,138.7	16,138.7
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	-	15,483.2	15,483.2
Хуримтлагдсан үр дүн	79,294.5	64,577.6	(14,716.9)
Өмнөх үеийн үр дүн	50,303.6	75,568.5	25,264.9
Тайлант үеийн үр дүн	28,991.0	(10,991.0)	(39,982.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	510.8	510.8	-
Дүн	97,877.5	112,285.4	14,407.9

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Засгийн газрын хувь оролцоо данс өсөхөд “Компанийн төрийн мэдлийн ногдол хувьд тооцон хөренгэ шилжүүлэх тухай” Төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг газрын 2024 оны 234 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХХ Улсын бүртгэлийн ерөнхий газраас 16,115.2 сая төгрөгийн, Мигасон ХХК-аас 15,483.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийг үнэ төлбөргүй хүлээн авсан нь нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлганаад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 92,345.8 сая төгрөгөөр төлөвлөх, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцож, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс урсгал зардлыг 4,787.4 сая төгрөгөөр нэмж, хөрөнгийн зардлыг 6,515.0 сая төгрөгөөр бууруулж, нийт төсвийг 90,618.2 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд анхны баталсан төсвийг 2,902.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 93,520.3 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 45,000.0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 43,244.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 1,756.0 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь тайлант онд 195000 дэлгэрэнгүй, 75000 энгийн лавлагааг цахимаар өгч, хуулийн этгээдийн бүртгэлийг цахимаар үсгэн байгуулдаг болж, тэдгээр төлбөртэй үйлчилгээг цахимаар үнэ төлбөргүй олгосонтой холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр урсгал зардлыг санхүүжүүлэхээр 90,605.6 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилтийг авч, 12.5 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг бүрдүүлсэн байна.

Баталсан нийт урсгал зардлын 96.9 хувь буюу 90,618.2 сая төгрөгийг зарцуулж, тайлант оны зарцуулаагүй 264.4 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 7. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70406	Улсын бүртгэл, мэдээлэл	93,520.3	90,618.2	2,902.1	96.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	48,461.4	48,231.8	229.6	99.5
80802	Ажил олгогчоос олгог тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	4,583.9	4,525.1	58.8	98.7
80220	Холбооны суваг ашиглалтын хөлс	594.1	593.6	0.5	99.9
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	14.3	14.2	0.1	99.3
81502	УИХ-ын сонгууль	3,039.0	3,039.0	-	100.0
81503	Орон нутгийн сонгууль	2,546.7	2,546.7	-	100.0
81521	Иргэний үзүүлэлт хэвлэж тараах	27,995.9	27,995.9	-	100.0
80918	Бусад /хөрөнгө оруулалт	6,284.8	3,671.7	2,613.1	58.4
	Төсөвт байгууллагын орлого	12.5	12.5	-	100.0

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт дээд шатны төсөв захирагчаас орон нутгийн нөхөн сонгуулийн 4,466.0 сая төгрөг, Орон нутгийн засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2,806.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, байрны түрээсийн орлого 1,534.3 сая төгрөг, нийт 8,806.7 сая төгрөгийн эх үүсвэрийг тус тус бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 1,333.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 171.3 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 9.1 сая төгрөг, эд хогшил, ургал засварын зардалд 9.1 сая төгрөг, дотоод албан томилолт, нормативт зардалд 5.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 118.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5,450.1 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 32.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 19.8 сая төгрөгийг тус тус зарцуулж, улсын төсөвт 1,658.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2024 оны А/07 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө"-нд нийт 8,104.1 сая төгрөгийн 11 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар баталж, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 8, шууд гэрээ байгуулах аргаар 3, нууцтай холбоотой 5 худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэл 5,151.6 сая төгрөг буюу 63.6 хувь байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн агентлаг, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүний шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн агентлагийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, харьяа байгууллагуудын өглөгийг бууруулах, баарын материал, хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүртэл аудитор Н.Нямсүрэн, Ж.Менхтуул нар гүйцэтгэх, хяналтыг ахлах аудитор П.Амарсаная, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 1/3209 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлын 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 83,866.9 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож, 838.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоо шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланда дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 9,721.1 сая төгрөгийн 8 зөрчил илрүүлж, зөрчлийг таслан зогсоох 9,721.1 сая төгрөгийн 3 албан шаардлага, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 4 зөвлөмж, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүллээ.

4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжжик эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага болон дээд шатны төсвийн захирачгаас төрийн хэмнэлттэй холбоотой тушаал, шийдвэр гарах, арга хэмжээ авах нөхцөл байдал үүсээгүй, 2024 оны баталсан төсвийт багтаан үйл ажиллагаагаа явуулсан байна.

4.3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоо журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн УБХ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 26.6 сая төгрөгийн 3 гүйлгээг мэдээлэлээгүй;
- Говьсүмбэр аймгийн УБХ 166.5 сая төгрөгийн 19 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй;
- Өмнөговь аймгийн УБХ 1-12 дугаар сард гэрээ хэлцэл байгуулах, захираганы шийдвэр гаргах, хөрөнгө зарцуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хөтөлж шилэн дансанд байршуулаагүй.

4.3.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.3.3.1 Албан шаардлага

1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК:

Илрүүлэлт 1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэртэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд үйлдвэрийн үндсэн 2 ажилтан орсон, тайланд онд Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, хууль, эрх зүйд нийцээгүй шийдвэр гаргаж, үр дүнгийн урамшуулал олгосон;

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хурлаар 2023 оны цэвэр ашгийн 3,726.0 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр олгох, ногдол ашгийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн олгох, тус ногдол ашгаар Унгар улсад 938,906 европийн чилтэй гадаад паспортын бэлдцийн өр төлбөрийг бүрэн төлж, барагдуулах санаалыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлэх шийдвэрийг гаргасан.

Эн нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-т "Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэвлэлцэн шийдвэрлэсэн", 75 дугаар зүйлийн 75.6-д "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдолд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно", 79 дүгээр зүйлийн 79.1.2-т "өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хуульд нийцүүлэн томилоогүй. Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, хуульд нийцүүлэн үр дүнгийн урамшуулал олгох, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг гаргаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тайлант оны бизнес төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд төлөвлөж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж батлуулахгүйгээр 5,968.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Эн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх-/ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захираганы байгууллагад хүргүүлнэ", 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүргээ зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захираганы байгууллага, Сангийн яамаар зардлын дээд хязгаарыг батлуулна" гэж заасныг тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны бизнес төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд төлөвлөж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн



жагсаалтыг гаргаж, батлуулаагүй зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3.

1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр буюу Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас 4 хоногоор хоцроон Үндэсний аудитын газарт ирүүлсэн;
2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1-1/41 дүгээр албан бичгээр ирүүлсэн нь Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанаас 20 хоногоор тус тус хоцроож ирүүлсэн тус тус хоцроож, ирүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9-д "Төрийн болон орон нутгийн өмчийт, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ", мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хучин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.2-т "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан болон зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд гаргаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй буруутай албан тушаалтанд сахилгын хариуцлага ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

4.3.3.2 Зөвлөмж

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК

Илрүүлэлт 1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, батлуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт зардал гаргахгүй, өөрсдийн нөөц боломжид тулгуурлан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Илрүүлэлт 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хийж, дүгнэлт ирүүлээгүй байхад Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийж, дараах шийдвэрүүдийг гаргасан нь хүчин төгөлдөр бус болох эрсдэлтэй байна. Үнд: Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 24/01 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар баталж, бүтэц орон тооны дээд хягаарыг захиргаа, удирдлагын алба 12, Үйлдвэрийн алба 35, санхүү, аж ахуйн алба 11, нийт 58 орон тоогоор баталсан боловч гүйцэтгэлээр захиргаа, удирдлагын алба 13, Үйлдвэрийн алба 29, санхүү, аж ахуйн алба 9, ТУЗ-ийн гишүүн 7, нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан нь үндсэн үйлдвэрийн ажилчдын орон тоо дутуу, удирдах албан тушаалтны орон тоо хэтрэх эрсдэлтэй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5-д “Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн эзлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуулийн хугацаанд хуралдуулж, хуульд нийцсэн шийдвэр гаргаж байх, орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах.

4.4 Судалгааны үр дүн

Аудитын явцад ахмадын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад судалгаа хийж үзэхэд тус санд төвлөрүүлэх хөрөнгийг төсөвт төлөвлөж, батлаагүй байхад нэр бүхий аймгийн УБХ тайлант онд 112.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 86.3 сая төгрөгийг зарцуулж, 151.1 сая төгрөгийн үлдэгдлэлтэй байна.

Тайлант хугацаанд бусдаа гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас /210801/ үндсэн үйл ажиллагааны зардалд 251.2 сая төгрөг, мэдээлэл, сурталчилгааны зардал 14.2 сая төгрөг, холбооны суваг ашигласны зардалд 564.2 сая төгрөг, иргэний үнэмлэх хэвлэж тараах зардалд 5,295.9 сая төгрөг, гадаад паспортын үйлчилгээний орлогоос төлсөн гадаад паспортын бэлдцийн төлбөр 10,477.4 сая төгрөг, гэрээний дагуу төвлөрүүлсэн, зарцуулсан орлого 3.5 сая төгрөг, нийт 16,632.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бараа үйлчилгээний зардлаас /210901/ Улсын Их Хурлын сонгуульд 6,219.9 сая төгрөг, орон нутгийн сонгуульд 4,788.9 сая төгрөг, иргэний үнэмлэх хэвлэж тараахад 22,700.0 сая төгрөг, ахмадын санд 12.0 сая төгрөг, нийт 33,720.8 сая төгрөг зарцуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланц хийсэн завсрын аудитаар нийт 615.1 сая төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлэн 143.9 сая төгрөгийн 1 алдааг запруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 365.2 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 106.0 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөреөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар төвлөрүүлэн захирагчид өгсөн 28.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,518.2 сая төгрөгийн 3 албан шаардлага, 9,568.0 сая төгрөгийн 6 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт			Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	
Төлбөрийн акт	1	28.0	1	28.0	100.0	
Албан шаардлага	3	1,518.2	3	1,518.2	100.0	
Зөвлөмж	6	9,568.0	6	9,568.0	100.0	
Дүн	10	14,540.8	10	14,540.8	100.0	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, түүний хэрэгжилт мөн ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтийг онцгойлон авч үзэх шаардлагатай байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд бараа материал болон үнэт цаасны худалдан авах ажиллагаа, зарцуулалт, хадгалалт хамгаалалт, цалин орон тоо, албан хаагчдын цаг ашиглалт, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн хөрөнгийн үнэлгээг дараагийн аудитаар авч үзэхээр байна.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 24 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 15 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 9 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан 15 байгууллагын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 30,164.1 сая төгрөгийн 72 алдаа, зөрчлийг илрүүлж, аудитын явцад 2,257.5 сая төгрөгийн 28 алдааг залруулж, 43.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 27,816.3 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага хүргүүлж, 46.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 18 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 27,906.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 27,067.9 сая төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Үүнээс: Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 28,208.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг¹ илрүүлж, аудитын явцад 301.6 сая төгрөгийн 4 алдааг залруулж, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 27,906.6 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүллээ.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 183.6 сая төгрөгийн үйлчилгээний орлогыг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн;
- Сэлэнгэ аймгийн УБХ-ийн санхүүгийн байдлын тайланд 9.0 сая төгрөгийн хангамжийн материалын үлдэгдлийг дутуу тайлагнаж, и-тайландаа шивсэн;
- Өмчийн өөрчлөлтийн тайланд Дархан-Уул аймгийн УБХ-ийн шилжүүлж авсан 23.5 сая төгрөгийн газрыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд Төв аймгийн УБХ-т орон нутгийн 85.5 сая төгрөгийн санхүүжилтийг мөнгөн орлогоор хүлээн зөвшөөрч, бүртгээгүй.

5.1 Төлбөрийн акт

1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК

Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт 1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн 2 ажилтан 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр эрх баарих этгээдийн мэдээлэлд бүртгэгдэж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болсон боловч тайлант онд үндсэн ажилтнаар ажиллаж, нийт 36.4 сая төгрөгийн цалинг давхардуулан авсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6-д "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдолд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно", 79 дүгээр зүйлийн 79.1.2-т "өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэгтүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд үндсэн ажилтнаар ажиллаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалинтай давхардуулан авсан 36.4 сая төгрөгийн цалинг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

¹ Хучин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1. Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д:

Илрүүлэлт 1. Бараа материалын дансанд нийт 15.9 сая төгрөгийн 90 гр, 120 гр, 75 гр-ийн 3 төрлийн нийт 25000 ширхэг хэрэгцээ шаардлагагүй, хээтэй цаас нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Санхүү, төсвийн зохистой удирдах, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүү, төсвийг зохистой удирдаж, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулаагүй, бараа материалыг их хэмжээгээр бэлтгэж, нөөцөлсөн зөрчлийг таслан зогсоож, дахин гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Бараа материалын хорогдолтой холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. "Бараа, материалын хэвийн хорогдлын хэмжээ батлах тухай" Засгийн газрын 2019 оны 467 дугаар тогтоолын хавсралтад тусгагдаагүй буюу Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн тогтоол, шийдвэр гаргаж, хэвийн болон хэвийн бус хорогдол тооцох норм, нормативыг баталж, дагаж мөрдөөгүй;

2. Устгалд оруулбал зохих материалын тоо, хэмжээ 2023 онд 20116 ширхэг байсан бөгөөд тус хорогдлыг устгасан комиссын шийдвэр, акт, дүгнэлт байхгүй;


3. 2024 онд 16687 ширхэг материалын хорогдол байгаа боловч тайлант онд багтааж, эрх бүхий комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлээгүй, тус хорогдол ямар шалтгаанаас үссэн гэдгийг тодорхойлоогүй байгаа нь ашиглан, шамшигдал гарах мөн төсөөт төвлөрүүлэх ногдол ашигийг бууруулах эрдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буурутай хүмүүсээр төлүүлнэ. Сангаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, материалын хорогдол үссэн шалтгааныг тогтоох, хорогдлыг хэрхэн тооцох, устгалд оруулах асуудлыг хэн хариуцах, хэрхэн шийдвэрлэхийг компанийн дүрэм, дотоод журамд тусгагаагүй, устгалд оруулбал зохих бараа материалыг их хэмжээгээр хадгалсан зөрчлийг таслан зогсоож, дахин гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааны жагсаалтад ороогүй 24,181.8 сая сая төгрөгийн үндсэн түүхий эд материалыг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох", 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчтэй болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бурийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал/цаашид "зорилтын санал" гэх-/ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 13 дах хэсгийн 11-т "Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр", мөн хэсгийн 12-т "байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт", Төрийн болон орон нутгийн



өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн нууцад хамаарах жагсаалтад батлагдаагүй үндсэн түүхий эд материалыг нээлттэй тендер шалгаруулахгүйгээр худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, дахин гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 24/03 дугаар тогтоолоор 160кв-ийн зөөврийн цахилгааны эх үүсвэрийг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртийн дээд хязгаарт заасныг зарчин 141.7 сая төгрөгийн барааг нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр харьцуулалтын арга ашиглан худалдан авсан байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 32 дугаар зүйлийн Нээлттэй тендер шалгаруулалтын арга 32.1-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргын хэрэглэнэ". Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн яамаар зардлын дээд хязгаарыг батгуулна", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртийн дээд хязгаарыг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Улсын бүртгэлийн ерөнхий газарт:

Илрүүлэлт 1. Аудитаар бараа материалын тооплого хийхэд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д хүлээлгэн өгсөн, цахим гадаад паспортын 1664 ширхэг 113.7 сая төгрөгийн бэлдэц бодитоор оршин байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1-т "Ажилтан дараах тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ", 131.1.2-т "эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулсан, эсхүл хөдөлмөрийн гэрээнд энэ тухай тусгайлан тохирсон ажилтан ажил үүргээ гүйцэтгэх үедээ ажил олгогчид хохирол учруулсан", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооплого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д 1664 ширхэг цахим гадаад паспортын бэлдцийг бодитоор хүлээлгэж өгөөгүй, бараа материалын тооплогыг бүрэн

хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 3,172.3 сая төгрөгийн болгоно хувьгаат эд төлбөр үсгэж, барагдуулах арга хэмжээг авч, ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодог дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохицтой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг тус тус зэрчсэн байна.

ШИЙДВЭРЛЭСН НЬ: Эр төлбөр үүсгэж, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зэрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг хургуулэв.

Илрүүлэлт 3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 27,906.6 сая 43 зөрчил илэрснээс 43,482.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 27,816.3 сая төгрөгийн 23 албан шаардлага хургуулж, 46.8 сая төгрөгийн 18 зөвлөмж ёгсөн нь харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн ўйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангальтгүйтэй байна.

Эн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т "дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлангнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгох, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.6-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллааг, албан тушаалтын өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцигаа хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түнд харьялгадах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, давтан гаргахгүй байх, хувь тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган ҮАГ-т ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа	Буруу тусган ицээрхийлсан		Үүнээс Залцуулсан		Үүнээс Залцууллаагүй		/сан төгрөөөр/ Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Архангай аймгийн УБХ	1	11.8		1	11.8				
Бултан аймгийн УБХ	1	3.5		1	3.5				
Говьсумбэр аймгийн УБХ	1	2.3		1	2.3				
Говьсумбэр аймгийн УБХ	1	0.9		1	0.9				
Дархан-Уул аймгийн УБХ	1	31.5		1	31.5				
Дархан-Уул аймгийн УБХ	1	153.9		1	153.9				
Орхон аймгийн УБХ	1	23.5		1	23.5				
Орхон аймгийн УБХ	1	16.7		1	16.7				
Өвөрхангай аймгийн УБХ	1	1.4		1	1.4				
Өвөрхангай аймгийн УБХ	1	7.1		1	7.1				
Өмнөговь аймгийн УБХ	1	92.0		1	92.0				
Төв аймгийн УБХ	1	85.5		1	85.5				
Төв аймгийн УБХ	1	199.6		1	199.6				
Төв аймгийн УБХ	1	3.3		1	3.3				
Үсүү аймгийн УБХ	1	0.6		1	0.6				
Хөвд аймгийн УБХ	1	0.5		1	0.5				
Хөвд аймгийн УБХ	1	17.4		1	17.4				
Хөвд аймгийн УБХ	1	2.4		1	2.4				
Хөвд аймгийн УБХ	1	1,284.2		1	1,284.2				
Нийслэлийн Улсын бургэлийн гаазар	1	2.4		1	2.4				
Нийслэлийн Улсын бургэлийн гаазар	1	1.3		1	1.3				
Нийслэлийн Улсын бургэлийн гаазар	1	0.8		1	0.8				
Улсын бургэлийн өрөөний газар ТТЗ	1	183.6		1	183.6				
Улсын бургэлийн өрөөний газар ТТЗ	1	9.0		1	9.0				
Улсын бургэлийн өрөөний газар ТТЗ	1	23.5		1	23.5				
Улсын бургэлийн өрөөний газар ТТЗ	1	85.5		1	85.5				
НИЙТ	28	2,257.5	-	-	28	2,257.5	-	-	-

САНХУГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧУЛИЙН НЭГТГЭЛ

/сая төрөөвөр/							
№	Байгууллагын нэр	Зөрчийн товч утга			Абан шаардлага		
		Нийт	Акт	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	УБЕГ ТТЗ	Улсын бүртгэлийн өрөөний газрын 2024 оны санхүүгийн нэгжтэсэн тайланда хийсан аудитгаар нийт 28,264,241 б өмнөгэн төгрөгийн 46 зөвлөхийн элэрсээс 2 төгрөгийн 2 төлбөрийн акт тогтох, зөвлөхийг арилгах, давтсан гаргахийг байх 27,816,295.4 мянган төгрөгийн 23 албан шаардлагын хургуулж, 46,815.5 мянган төгрөгийн 18 зөвлөхийг чигжжин хариуцлагын тооцуулах 1 албан байгууллагад, энгэжилж, 357,647.9 сая төгрөгийн 1 асуудлыг хүчлийн зөвлөхийг шийдвэрлэсэн биеөдөр нийтийн асуудлаар 9,721,074.8 мянган төгрөгийн 8 зөвлөхийг илрэсэн байна.	1	-	1	-	-
2	УБЕГ ТТЗ	Тайлант онц төслийн төвтүүрүүн замжирчилж тайланда баяндаалуухаа талаар арга хэмжээ авч ажиллажтай байна. Бараа материалын тоологоо хийждэг УБЕГ-ас хүлээж авсан цэхийн гадаад, паспортын 113,680 өдөртэйнээд үүний дундаж 1664 ширхэг бэлдэц болдигүй оршиж байжийг байна.	1	3,172.3	1	3,172.3	-
3	УБЕГ ТТЗ	Бараа материалын тоологоо хийждэг УБЕГ-ас хүлээж авсан цэхийн ширхэг бэлдэц болдигүй оршиж байжийг байна.	1	113.7	1	113.7	-
4	Дархан-ул УИХ	Акт: Тайлант онц байгуулжийн албан хөгжлийн орон нутагт ажилласны нэмэлт цэлийн илүү олонссон байна.	1	7.1	1	7.1	-
5	Төрийн үзт цаас хавьлэл ТӨДХХК	Одамартушин: Р. Айтшин-Төллийн нар 2023 оны 04 дугаар сарын 08-ны эхийн эрх барих элтээлээд Мэдээлэлээдэл, бүртгэлдээж, түз-чинь шийцүүн болсон биеөдөр 2024 онд компанийн үндэснээж ижитжнаар ажиллаж, нийт 109,829.0 мянган төгрөг, ТУ-3-д ажиллаад 40,783.6 мянган төгрөгийн цэлийн давхарзүүлж авсан байна.	1	36.4	1	36.4	-
6	Төрийн үзт цаас хавьлэл ТӨДХХК	Бараа материалын дансанд 15,885.4 мянган төгрөгийн үйнийн дундаж 90 гр, 120 гр, 75 гр-чин 3 төрлийн нийт 25000 ширхэг ширхэгийн шаардлагатай, хэзэтийн цэвс нэвчлэлтэн байна.	1	15.9	1	15.9	-
7	Төрийн үзт цаас хавьлэл ТӨДХХК	"Бардаа, материалын хэзээн хордлын хэмжээ батлах тухай" Засгийн газрын 2019 оны 467 дугаар тогтолцооны хувьраатад тусгайгүй, хэзийн хордол тооцох норм, нормативын байхгүй, устгалаа оруулж болсон 2023 оны 04 дугаар сарын 08-ны ширхэг төгрөгийн үзэлжилж санхүүгийн тайланда бүртгэлтийн байна. Хордлогод тооцсон, устгалаа, оруулсан комиссын актүүй, хэзэн хариуцахыг дотород дүрэм, журамд туслахийгээ залжлан гарах эрээштэлжэй, тасралт төвтүүрүүлэхээр төвлөвлөсөн ногдол ашигийт буудлуулж байна.	1	-	1	-	-
8	Төрийн үзт цаас хавьлэл ТӨДХХК	Хувьцаа эзэмшилжийн хүртэл 2024 оны 24/03 дугаар тогтолцоор 160вийн эзэвчиний цахилгааны эх үзүүлэлтэй худалдан авахад Төрийн үзт цаас хавьлэл ТӨДХХК	1	-	1	141.7	141.7

REVIEWS



		хархуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, улчилгээний төсөвт ёртгийн дээр хязгаарт заасны зорхион байгуулхүйэр харьцуулалтын арга ашиглан худалдан авсан байна.				
9	Төрийн үнэт цаас хувьзл ТөдХХК	Төрийн нууцад хамаарах худалдан авалтын жагсаалтад ороогийн баяхад Жордан Топлен Трек ХХК-тай үндсан түүхий эд мэдэрэлтэй гэрээ байгуулж, худалдан авалт хийсан байна.	Аймгийн Засаг дарын 02 сарын 06-ны өдрийн А/48 дугаар захиалжин дагуу хэлтсийн даргат 1,757.0 мянган төгрөгийн, Хэлтэстийн дарын 2024 оны 05 сарын 27-ны өдрийн Б/11 дүгээр тушаанаар алхас нийтлан болонч 1,471.0 мянган төгрөгийн нийт 3,328.0 мянган төгрөгийн урамшууллыг цэлийнлийн сангаас олж багтавдсан төслийг зориулалт бусаар зардуулсан байна.	1	24,181.8	1
10	Архангай аймгийн УБХ	ҮБЕГ-ын дарын 2024.10.11-ний өдрийн Наг үзүүтэн буцаатгүй барьшээлтэй албан хаягдад 1 сарын үндсан цалингийн Тэнцэх хэмжээний нэг үзүүтэн буцаатгүй туслаамж олгох шийдвэрээр цалингийн зардлаас 1,452.0 мянган төгрөгийг олгосон байна.	Байгуулалтын дарын 2024 оны А/18 дугаар тушаалаар цалингийн сангаас нийтлан 0 мянган төгрөгийг олгосон байна.	1	1.5	1
11	Баянконтор аймгийн УБХ	Орхон аймгийн Засаг дарын Тамлын гарын 2023 оны Үйл ажиллагааны ерөнхий чуулга эзэр индэр оноо авсантай холбогдуулан гарасан аймгийн Засаг дарын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/767 дугаар захиржийн үндэслээн нийт 5,431.5 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын ҮР дүүргин мөнгөн урамшуулалттай давхардуулсан олгосон байна.	Байгуулалтын дарын 2024 оны А/18 дугаар тушаалаар цалингийн сангаас нийтлан 0 мянган төгрөгийг олгосон байна.	1	1.5	1
12	Булган аймгийн УБХ	Туслаамжийн үзүүтэн материйлүүлж, цавс/ 8,959.3 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримт бурдлуултууд төрөлжиний өмнөговь аймгийн Засаг дарын "Жуух бичиг"-эр шигнэгдсан 4 албан хаягчид шалтайн дагдаадаа мөнөн урамшуулалт болох хөрөнгийг зориулалт бусаар зардуулсан байна.	Тайлант онд багаж техник хэрэгслийн зэрдаас урсгал засварын зардаад 206.4 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн аниипл хооронд гүйцэтгэн зориулалт бусаар зардуулсан байна.	1	9.0	1
13	Орхон аймгийн УБХ	Тайлант онд багаж техник хэрэгслийн зэрдаас урсгал засварын зардаад 206.4 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн аниипл хөрөнгийг зориулалт бусаар зардуулсан байна.	Төлөөр тооцоог үрдүүчлэн хөнгөнчийн үзүүлэлтэй давхардуулсан шилжүүлж, 10,557.9 мянган төгрөгийн авалга үүсгэсэн байна.	1	0.2	1
14	Өвөрхангай аймгийн УБХ			1	10.6	1
15	Омноговь аймгийн УБХ			1	10.6	1
16	Сээнэг аймгийн УБХ			1	10.6	1
17				1	10.6	1

		ажлын 20 хоног амрахвар олгосон байхад нийтлан бодогч 2.3.4.6.8						
30	Өмнөговь аймгийн УБХ	Дугаар саруудад 1-5 хоногоор хэсэгчлэн амарсан байна. Тайлант онц үйл залгын төхөнгөй үзүүлэлттэй дэвхэрчдүүлжин олгосон байна.	1	-			1	-
31		Тайлант онц үйл залгын төхөнгөй үзүүлэлттэй дэвхэрчдүүлжин олгосон байна. Төвлөвсний эзах на нотлоодоогүй байхад оны эсчин үзүүлэлт 14.203.7 мянган төгрөгийг Ахмадын санд төвлөрүүлжин байна.	1	-		1	-	
32		Элэгдлээрээз анхны өртөө нэхжэж, улдах өргөтгүү болсон 236 шархж үндсан хөрөнгийн дахин үнэлж данс бүртгэдэг туслаатай байна.	1	-		1	-	
33	Төв аймгийн УБХ	Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсан цалингийн зөвүүг тооцож олгосдоно замаардудуйг тооцож үндсэн цалингийн зөвүүг тооцож олгосон байна.	1	-		1	-	
34		Албан хаагчдын цалингасаас суптасан ХХОАТ-ын зөвүүг тохижуулалгүй, токхижуулалын тайланы хийгээгүй байна. ҮБЕГ-ын дарын 2019 оны Б/178 дугаар тушаалтаар гэрээтийг албан хаагчдын орон гонь дээд хэзгийнгээ 3-аар багасан байхад орон тоог хэтрүүлэн б-арж ажиллуулсан байна.	1	-		1	-	
35		Ур чадварын намэгдлийг тушавшийдвэрлжийг олгосон.	1	-		1	-	
36	Хөвд аймгийн УБХ	Аймгийн УБХ нь ахмадын сан байгуулж ажиллаатай байна.	1	13.5		1	13.5	
37	Хөвсгөл аймгийн УБХ	Нүүрг бичиг хэрэг, аж ахуй хангамжийн материалын худалдан авах гэрээнд баргаа материалын тоо ширгэж үзүүлж туслаатай.	1	-		1	-	
38	Нийслэлийн УБГ	Улсын бургатгийн өрөөжийн газрын 2021 оны А/706 тушаалаар батасан "Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортын бэлдэцийг хүлээн авах, олгох, зарцуулалтад тавих журмын"-ыг шинжилж багасгыгийг байна.	1	28.2		1	28.2	
39		Монгол Улсын нутаг дэвсгээрт багасгаа "терийн болон албаны нүүцүүн тухай" хувьдаа засвсаас бусад торийн өмчийн Ул хедлех захынгийн эрхийн эрхийн улсын бургатгалд бургатгал журамж-ыг 2018 оносс хойш багасгыг багасгас төрийн өмчийн Ул хедлех захынгийн эрхийн эрхийн улсын бургатгалд бургатгыг байна.	1	-		1	-	
40	Улсын бургатгийн өрөөжийн газар/төөв аппарат/	Койс машин буюу Голомт банкны /48-тai/ дансанд, төвлөрсөн орлог, тортгуй, улсын тэмдэгийн хураамжийг антилж, бүртгэх программын хөржилжүүлж хийгээгүйгээс тус дансанд төвлөрсөн орлогыг мөрчнөт буюу бөөн дүнгээр татаж байгаа нь улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж орлогыг зөвүүгээ тайлланах эрдээлтэй байна.	1	-		1	-	
41								

42	Төсвийн төвлөрүүлээн болон шууд захиалгийн санхүүгийн тайландаа өмнөх аудитгаар өгсөн шийдвэрлийн хэрэгжүүлах ажлын төлөвлөгөөг 2024 оны 04 дугаар сарын 09-ний өдрийн 1/4624 дүгээр албан бичигээр хамтгатсан УАГ-тийн түүслээн байна.	1	-				1	-
43	Барын материалын дансанд 897,752.0 мянган төгрөгийн 30000 ширэг уйлдвэрийн алдаатай дахин ашиглах боломжгүй цахим гдаадц паспорт бэлдээч бүртгэлтэй байна.	1	-				1	-
44	Дансны анчилалт зөвчин гэвээр шатахууны зардлаас бичиг хэлгийн зардалд 1,479.5 мянган төгрөг, ариутгатал хайдваргүйжүүлэлттүйн төбөөрт 304.3 мянган төгрөг, цэвэрлэгээний материалын худалдан авах зардалд 1,541.9 мянган төгрөг тус зарцуулсан байна. НИИЖТ	1	3.3				1	3.3
	44	27,906.6	2	43.5	24	27,816.3	18	46.8



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Байгууллаг ын нар	Зэрчлийн төвч утга	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг холбоотой асуудал						/сая төгрөгөөр/ Харчуулага тооцуулах албан шараадлагыг Албан тушаалт
			Нийт		Албан шараадлага		Зөвлөмж		
			Тоо	Дун	Тоо	Дун	Тоо	Дун	
1	Баянхонгор аймгийн УБХ	Тайлант онц шилэн дансны цахим хуудсанц 1,452.0 мянган төгрөгийн 3 тушаал, цалингийн зарысад 5 сая төгрөгөөс түүлгээгээгийг байна.	1	26.6	1	26.6			
2	Говьсүмбэр аймгийн УБХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанц 166,548.7 мянган төгрөгийн 19 мэээлгийн хугацаанд нь байгуулаагүй.	1	-			1		
3	Өмнөговь аймгийн УБХ	1-12 дугаар сарын 19-ээдээгийн хугацаанд 1-12 дугаар сарын 19-ээдээгийн хугацаанд нь байгуулаагүй, гаргах, хөрөнгөн зарцуулнаас ашиг сонирхлын зөвлөлийг гэгээдэг илрэхийнхэз зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хөтөлж шилэн дансанд байгуулаагүй байна.	1	-			1		
			3	26.6	1	26.6	2	-	0
			Бусад хувь тогтоложийн хэрэгжилтийг холбоотой асуудал						
4	Төрийн үнэт цаас хавлэг ТӨДХХК	Төрийн үнэт цаас хавлэл ТӨДХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланц хийсан аудитар Хувьцаа зэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэртэй холбоотой дараах зөрчил илэрээ. Үүнд:							
		1. Төлөөлөн удирдах хийсэн 2. ажилтан орсон, тайланц хувьцаа зэмшигчийн хурлыг хууль зассан хугацаанд хийгээгүй, хувь зүйд нийцэгчийг шидвэр гаргаж, ур дунгийн урамшуулал олгосон;							
		2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 3.726.014,146.00 онд тэрбум доллоон зүйн хорин зургаан сая арван дорвөн мянган нэг зуун дунчин зургаан/ төгрөгийт хувьцаа зэмшигчдэд мянган халбарэр олгох, ногдол ашгийг 2024 оны 8 дугаар саарын 9-ний едрийн хурлаар 3.726.014,146.00 тэрбум доллоон зүйн хорин зургаан сая арван дорвөн мянган нэг зуун дунчин зургаан/ төгрөгийт хувьцаа зэмшигчдэд мянган халбарэр олгох, эхэн олгох, тус ногдол ашгаар үнгар усласад 938,906	1	3,726.0	1	3,726.0			

		европийн чилтэй гдаадац паспортын бэлдцийн өр төлбөрийг бүрэн төлж, барагдуулах саналыг Хувьцаа эзэмшигчийн хуралд хургуулэх шийдвэрлийг гаргасан						
5	Төрийн үнэт цас хэвлэл ТӨДХХК	Тайлант оны бизнес төвлөөгөөт тухайн оны эхэнд төвлөж, хуульд зассан хугацаанд холбоотой байгууллагаад хургуулзагүй, чиг үргээз хэрэжжүүлэхэд, шаварлагатай эд, хөрөнгийн жагсаалтыг гаргаж багтуулчтайзэр 5,968.460.6 мянган төрөвийг зарцуулсан байна.	1. 2024 оны жилийн эдсийн санхүүгийн тайланг УЧДСНИЙ аудитын газарт 2025.03.20-ны өдөр буюу Төслийн тухай хуульд зассан хугацаанаас 4 хоног хонроон ирүүслэн байна.	1	5,968.5	1	5,968.5	
6	Төрийн үнэт цас хэвлэл ТӨДХХК	2. Омниекс аудитвар явесэн шийдвэрийн хэрэжжүүлэх ажлын төвлөгөөг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1-1/41 дүгээр аялан өнчгээр ирүүлсан нь Төрийн аудитын тухай хуульд зассан хугацаанаас 20 хоног хонроон ирүүлсан байна..	1	-	-	-	1	-
7	Төрийн үнэт цас хэвлэл ТӨДХХК	Нягтлан бодлог бүртглийн бодлолын баримт бичиг байхгүй байна.	1	-	-	-	1	-
8		ТУЗ-ийн хурал хийж, дунгцэлт ирүүлээгүй байхад ХЭХ-ыг хийж, хүчин төгөлдөр бус дараах шийдвэрүүдийг гаргасан байна. УЧД:						
		Төрийн үнэт цас хувцал ТӨДХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн хурлын 2024 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 24/01 дугаар тогтолцын хавсралт 2-т бугац орон тооны дээд хэлгарыг захирагаа. Удирдлагын алба 12, Үйлдвэрийн алба 35, санхүү, аж ахуйн алба 11, нийт 58 орон тоглогор багасан боловч гучцэлээгээр захирагаа, удирдлагын алба 13, Үлдэвэрийн алба 29, санхүү, аж ахуйн алба 9, ТУЗ-ийн тишүүн 7, нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан нь үндсэн үйлдвэрийн ажлынчдын орон тоо дутуу, удирдах албан тушаалтын орон тоо хэтэрсэн байна.	1	-	-	1	-	
		Нийцлийн нийт	5	9,694.5	2	9,694.5	2	1
			8	9,721.1	3	9,721.1	4	1





ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР
АКТ

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 209/00140083
СНМГР-2025/012/ИА-СТА-786Г

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланц хийсан аудитаар дараах зөрчил илрэлзэ.

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн 2 ажилтан 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр эрх барих этгээдийн мэдээлэлд бүртгэдэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болсон боловч тайлант онд үндсэн ажилтнаар ажиллаж, нийт 36,419,999.40 /Гучин зургаан сая дөрвөн зуун арван есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг дөчин мөнгө/-ний цалинг давхардуулан авсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6-д "Хувьцаат компанийн хувьцаа зазэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүний төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдолд тухай компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно", 79 дүгээр зүйлийн 79.1.2-т "өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаалт эрхэлдэгтүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаалт эрхэлж байгаагүй" гэж заасныг тус тус зөрчсөн байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн ёмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны №95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үйлдвэрийн үндсэн ажилтнаар ажиллаж, тайлант онд давхардуулан авсан 36,419,999.40 /Гучин зургаан сая дөрвөн зуун арван есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг дөчин мөнгө/-ний цалинг буруутай этгээдээр нехэн төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн Гүйцэтгэх захирал (Э.Ариунгэрэл), Ахлах нягтлан бодогч (Б.Дэлгэрхам) нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГООСОН:

САНХҮҮ, НИЙЦГИЙН АУДИТИН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Г.Ж.Н.* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТИН МЕНЕЖЕР *Г.А.* Б.ДОЛГОРСҮРЭН
АХЛАХ АУДИТОР *Г.А.* П.АМАРСАНАА
АУДИТОР *Г.А.* Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26423

2.v6.2025.0323.0N4G-16.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 адар

Дугаар 877/A0140088

Улаанбаатар хот

СНАГ-2025/014/НА-СТА-ТВТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хөвлэл ТӨДХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланад хийсэн аудитаар Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэртэй холбоотой дараах зөрчил илрэлзээ. Үнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд үйлдвэрийн үндсэн 2 ажилтныг томилж, тайланд онд Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, хууль, дүрэм журамд нийцээгүй шийдвэр гаргаж, үр дүнгийн урамшуулалт олгосон;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хурлаар 2023 оны цэвэр ашгийн 3,726,014,146.00 /Гурван тэрбум долоон зуун хорин зургаан сая арван дөрвөн мянга нэг зуун дечин зургааг/ төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр олгох, ногдол ашгийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн олгох, тус ногдол ашгаар Унгар улсад 938,906 европийн чилтэй гадаад паспортын бэлдцийн ер төлбөрийг бүрэн төлж, барагдуулах саналыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлэх шийдвэрийг гаргасан.

Энэ нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-т "Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн", 75 дугаар зүйлийн 75.6-д "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-г заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдолд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй тооцогдоно", 79 дүгээр зүйлийн 79.1.2-т "өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой эттээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч эттээд хууль тогтоомж, захирагааны хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нехцэл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26423

Z:\4liban Shnerdige\20240325 SNAG-JS.Dokc

01

ТӨРИЙН АУДИТИН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТГАЙ
САИЛЛ ДУЧВЭЛИТ

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хуульд нийцүүлэн томилоогүй, Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, хуульд нийцүүлэн үр дүнгийн урамшуулалт олгох, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ын Хувьцаа эзэмшигч буюу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэхгүй (У.Болдхүү)-д даалгав.



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН

- Санхүүгийн тайлан болон зөвлөмжийн мереөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд гаргаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлзэгүй буруутай албан тушаалтанд сахилгын хариуцлага ногдуулж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ТӨДХХК-ын Гүйцэтгэх захирал (Э.Ариунгэрэл)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. Н.*
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

П. Амарсанаа
Амарсанаа

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2025 (0ны) 02 сарын 25 едер

Дугаар 879/A0170083

Улаанбаатар хот

СИАГ-2025/012/ИА-СТА-Т01

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хурээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК -ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илрэлзэ.

Бараа материалын дансанд нийт 15,885,427.28 /Арван таван сая найман зуун наян таван мянга дөрвөн зуун хорин долоон төгрөг хорин найман мөнгө/-ний 90 гр, 120 гр, 75 гр-ийн 3 төрлийн нийт 25000 ширхэг хэрэгцээ шаардлагагүй, хээтэй цаас нөөцлсөн байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохицтой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Санхүү, төсвийн зохицтой удирдах, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах". Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашигтгүүр удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдаг этгээд хууль тогтоомж, захираганы хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.7-д аливаа уйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

- Санхүү, төсвийг зохицтой удирдаж, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулаагүй, хэрэгцээ шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр бэлтгэж, нөөцлөн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирууллэх;
 - Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ын Гүйцэтгэх захирал (Э.Ариунгэрэл), Ахлах нягтлан бодогч (Б.Дэлгэрлхам) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНХАА
Н.НЯМСҮРЭН

*Монгол Улс, Уланбаатар хот,
Утас 51-26423*

Заснай газарын 4 дугээр бийр

ATA9893 900610

更多資訊請上網：www.taiwantravel.com.tw 或撥打服務專線：02-2722-2222

Z. Wilson-Shandaga 2023/01/23 SNAC-33 Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25

Дугаар 880/A0170083

Улаанбаатар хот

СНАГ-2025/012/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК -ын 2024 оны санхүүгийн тайландаа хийсэн аудитаар бараа материалын хорогдолтой холбоотой дараах зөрчлүүд илрэлзээ. Үнд:

1. "Бараа, материалын хэвийн хорогдлын хэмжээ батлах тухай" Засгийн газрын 2019 оны 467 дугаар тогтоолын хавсралтад тусгагдаагүй буюу Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн тогтоол, шийдвэр гаргаж, хэвийн болон хэвийн бус хорогдол тооцох норм, нормативыг баталж, дагаж мөрдөөгүй;
2. Устгалд оруулбал зохих материалын тоо, хэмжээ 2023 онд 20116 ширхэг байсан бөгөөд тус хорогдлыг устгасан комиссын шийдвэр, акт, дүгнэлт байхгүй;
3. 2024 онд 16687 ширхэг материалын хорогдол байгаа боловч тайлант онд багтааж, эрх бүхий комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлээгүй, тус хорогдол ямар шалтгаанаас үүссэн гэдгийг тодорхойлоогүй байгаа нь ашиглан, шамшигдал гарах мөн төсөөт төвлөрүүлэх ногдол ашигийг бууруулах эрсдэлтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ". Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага егнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

- Бараа, материалын хорогдол үүссэн шалтгааныг тогтоох, хорогдлыг хэрхэн тооцох, устгалд оруулах асуудлыг хэн хариуцах, хэрхэн шийдвэрлэхийг компанийн дүрэм, дотоод журамд тусгаагүй, устгалд оруулбал зохих бараа материалыг их хэмжээгээр хадгалсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Терийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ын Гүйцэтгэх захирал (Э.Ариунгэрэл), Ахлах нягтлан бодогч (Б.Дэлгэрхам) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *З.М.*
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25-адар

Дугаар 881/АО140083

Улаанбаатар хот

СНАГ-2025/012/НА-СТА-78УГ

Зөрчил арилгах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК -ын 2024 оны санхүүгийн тайландаа хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 24/03 дугаар тогтоолоор 160кв-ийн зөөврийн цахилгааны эх үүсвэрийг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт заасныг зерчин 141,725,100.00 /Нэг зуун дечин нэгэн сая долоон зуун хорин таван мянга нэг зуу/ төгрөгийн барааг нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр харьцуулалтын арга ашиглан худалдан авсан байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч өрөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 32 дугаар зүйлийн Нээлттэй тендер шалгаруулалтын арга 32.1-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллага, Сангийн яамаар зардлын дээд хязгаары баттуулна", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, телбэрийн акт тогтол юрам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нэхцэл үүссээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өргтийн дээд хязгаарыг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ын Гүйцэтгэх захирал (Э.Ариунгэрэл), Ахлах нягтлан бодогч (Б.Дэлгэрлхам) нарт даалгав.



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 888/10190083

Улаанбаатар хот

СНАГ - 2025/012/на-ста-7071

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК -ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсан аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тайлант оны бизнес төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд төлөвлөж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж баттуулахгүйгээр 5,968,460,621.47 /Таван тэрбум есэн зуун жаран найман сая дөрвөн зуун жаран мянга зургаан зуун хорин нэгэн төгрөг дэчин долоон мөнгө/-ийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх/ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллагад хүргүүлнэ", 24 дүгээр зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захирагааны байгууллага, Сангиин яамнаар зардлын дээд хязгаарыг баттуулна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

- Тайлант оны бизнес төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд төлөвлөж, холбогдох байгууллагад хүргүүлээгүй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж баттуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ын Гүйцэтгэх захирал (Э.Ариунгэрэл), Ахлах нягтлан бодогч (Б.Дэлгэрхам) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.ДОЛГОРСҮРЭН

П.АМАРСАНАА

Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264270

АТА7693 9030109
7023035583

Zellow Shortletgen-20250325 SNAG-35.Dscr



ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 883/АД190085

Улаанбаатар хот

СНАГ-2025/012/СТА-НА-ТВСТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК -ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төрийн нууцад хамаарах худалдан авалтын жагсаалтад ороогүй үндсэн түүхий эд материалыг гэрээт компаниас 24,181,750,000.00 /Хорин дөрвөн тэрбум нэг зуун наян нэгэн сая долоон зуун тавин мянга/ төгрөгийн гэрээ байгуулж, худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох", 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид "зорилтын санал" гэх-/ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захираганы байгууллагад хүргүүлнэ", 13 дах хэсгийн 11-т "Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төвлөрөн удирдах зөвлөлийн шийдвэр", мөн хэсгийн 12-т "байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авхаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулдагаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захираганы хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоо, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн нууцад хамаарах жагсаалтад батлагдаагүй үндсэн түүхий эд материалыг нээлттэй тендер шалгаруулахгүйгээр худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ын Гүйцэтгэх захирал (Э.Ариунгэрэл), Ахлах нягтлан бодогч (Б.Дэлгэрлхам) нарт даалгав.





ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 884/0140083

Улаанбаатар хот

СНАГ-2025/014/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 27,906,593,661.72 /Хорин долоон тэрбум есөн зуун зургаан сая таван зуун ерэн гурван мянга зургаан зуун жаран нэгэн төгрөг далан хоёр мянгэ/-ний 43 зөрчил илэрснээс 43,482,799.40 /Дөчин гурван сая дөрвөн зуун наян хоёр мянга долоон зуун ерэн есөн төгрөг дечин мянгэ/-ний 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 27,816,295,386.32 /Хорин долоон тэрбум найман зуун авсан зургаан сая хоёр зуун ерэн таван мянга гурван зуун наян зургаан төгрөг гучин хоёр мянгэ/-ний 23 албан шаардлага хүргүүлж, 46,815,476.00 /Дөчин зургаан сая найман зуун авсан таван мянга дөрвөн зуун далан зургаа/ төгрөгийн 18 зөвлөмж егсэн нь харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн ўйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйтэй байна.

Эн нь Төсвийн тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т "дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чигласэн төсвийн дотоод хяналтын ўйл ажиллагааг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлгагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.6-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, I-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26423

2.Ulaanbaatar/2023/0322/SNAG-15/Бэрс

ТОЛЫН АУДИТОН БАЙГУУЛАГА
ХЯЗГААРПАЛТЫЙ
САНЛ ДҮГҮЭТ

01

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн өрөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (У.Болдхүү), Бодлого төлөвлөлт, дун шинжилгээний газрын дарга (Т.Гантөмөр), Бодлого төлөвлөлт, дун шинжилгээний газрын дарга ахлах мэргэжилтэн (С.Энхнаран) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТИН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТИН МЕНЕЖЕР *Ч.М*
АХЛАХ АУДИТОР *Б.Долгорсүрэн*
АУДИТОР *П.Амарсаная*
АУДИТОР *Н.Нямсүрэн*



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 885/A0140083
СНАГ-2025/014/НА-СТА-773

Уланбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Аудитаар бараа материалын тооллого хийхэд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д хүлээлгэн өгсөн, цахим гадаад паспортын 1664 ширхэг 113,680,000.00 /Нэг зуун арван түрвэн сая зургаан зуун наян мянган/ төгрөгийн бэлдэц бодитоор оршин байхгүй байна.

Эн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Сангаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрэ баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1-т "Ажилтан дараах тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ", 131.1.2-т "эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулсан, эсхүл хөдөлмөрийн гэрээнд энэ тухай тусгайлан тохирсон ажилтан ажил үргээ гүйцэтгэх уедээ ажил олгогчид хохирол учруулсан", Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үндэгдлийн баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирагааны хэм хэмжээний болон бусад эрх зүн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоо, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэг (У.Болдхүү), Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Өзлүн-Үжин) нарт даалгав.

- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д 1664 ширхэг цахим гадаад паспортын бэлдцийг бодитоор хүлээлгэж өгөөгүй, бараа материалын тооллогыг бүрэн хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэг (У.Болдхүү), Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Өзлүн-Үжин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Г. Амарсанаа
Г. Амарсанаа
Г. Амарсанаа

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Уланбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойрууч, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

АТА19693 90:3109
СУРВИЗЫН

Z:\Ulan\SheardLogo\2025\0123\SNAG-33.Docx

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА
ХЭЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДУГЭЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 886/10190083

Уланбаатар хот

СМАГ-2025/014/НА-СТА-773

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрээз.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 3,172,284,849.04 /Гурван тэрбум нэг зуун далан хоёр сая хоёр зуун наян дөрвөн мянга найман зуун дөчин есөн төгрөг дөрвөн менге/-ний богино хугацаат өр төлбөр үүсгэж, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлагын төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлагын, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захираганы хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-т "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолон, төсөвт зардлыг хэтрүүлсэн", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрзэ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

- Өр төлбөр үүсгэж, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтсан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үргийг тур орлон гүйцэтгэгч (У.Болдхүү), Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга (Б.Өлзүүн-Үжин) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАД, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б.М.*
АУДИТЫН МЕНЕЖЕР *Г.Амурсанад*
АХЛАХ АУДИТОР *Н.Нямсүрэн*
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Уланбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26423

Z:\Ulan Shan\bolgo\2025\0325\SMG-35.Docx